

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: *35/10кВ-н Даланжаргалан дэд станцын 10кВ-н хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлын материал нийлүүлэх тендерийн баримт бичиг*

Тендер шалгаруулалтын дугаар: ХА №19/37

Боловсруулсан ҮХН бичгийн дарга:

Г.НАРАНЦЭЦЭГ
/Төсвийн мэргэжилтэн/

Хянасан ҮХ дарга:

С.БОЛД
/ЗУРХА-ын албаны дарга/

Гишүүд:

А.ЭНХБАТ
/Санхүү эдийн засгийн
хэлтсийн дарга/

Ц.ЭНХБАТ
/Хөндлөнгийн гишүүн/

Б.ТУЯА
/Хөндлөнгийн гишүүн/

Хаяг: Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ийн конторын байр.

Утас: 99022755, 99990883

Факс: 70210167

ХА№19/39 тоот тендерийн урилга

ХА19/39 дугаартай 35/10кВ-н Даланжаргалан дэд станцын 10кВ-н хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг : Улаанбаатар хот Багануур дүүрэг үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99022755. 99990383

Факс: 70210167

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар ирүүлэх 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар , НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ. 4. 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайланг, дүгнэлтийн хамт ирүүлнэ. 5. Сүүлийн хоёр жилийн нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. / үнэлгээнд www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ/ 6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-ын тодорхойлолтыг тус тус ирүүлнэ 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /татварын тодорхойлолтыг үнэлгээнд www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ./ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт, фото зураг , дагалдах баримт бичгийн хамт ирүүлэх . /Үзүүлэлт нь захиалагчаас өгсөн техникийн шаардлага хангасан байх ба сүүлийн үеийн шинэлэг давуу талтай байж болно/ 9. Тендерийн баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим хаягаар ирүүлнэ. 10. Нийлүүлэгч ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 11. Нийлүүлэх хугацаа 21 хоногоос ихгүй , хүргэх газар Багануур дүүргийн үйлдвэрийн хэсгийн “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад . 12. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа байршил, захиалагчийн хаяг, холбоо барих утас зэргийг тусгасан жагсаалт ирүүлэх. Мөн гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. 13. Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.
ТӨӨЗ 2.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99022755, 99990883
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг: Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар тендерийн баримт бичгийг авна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 09 дугаар сарын 18 –ний өдрийн 15 цаг 00 минутад.
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх хугацаа нь: 2019 оны 09 дугаар сарын 18 ний өдрийн 15 цаг 30 минутад цахим системээр нээнэ.
ТӨӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр дугаар бүхий байна: ХА.№19/39 “35/10кВ-н Даланжаргалан дэд станцын 10кВ-н хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлын материал нийлүүлэх” Багцтай эсэх: Үгүй

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТОО ХЭМЖЭЭ

д/д	материалын нэр	хэмжих нэгж	тоо хэмжээ	Тайлбар
1	10 кВ ячек бүхий секц холбогч вакуум таслууртай иж бүрэн хуваариалах байгууламж /гадаа байрлуулах зориулалттай/	ком	1	Техникийн тодорхойлолтонд заасан шаардлага хангах
2	10кВ-н ячек бүхий цэнэг шавхагч гал хамгаалгчтай хүчдлийн трансформатор иж бүрэн хуваариалах байгууламж /гадаа байрлуулах зориулалттай/	ком	1	
5	Оператив хэлхээний тэжээлийн эх үүсвэр батерейн хамт	ком	1	
6	Кабель АВВГ 2*4	м	60	Техникийн тодорхойлолтонд заасан шаардлага хангах
7	Хяналтын зэс кабель 10*1.5	м	100	
8	Хяналтын зэс кабель 7*4	м	100	
9	Хөнгөн цагаан шин 100х10	м	60	
10	Гагнуурын электрод	кг	10	

**10 кВ-ын ЯЧЕЙК БҮХИЙ ЦЭНЭГ ШАВХАГЧ,
ГАЛ ХАМГААЛАГЧТАЙ ХҮЧДЛИЙН ТРАНСФОРМАТОРЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

10 кВ-ын ячейк нь олон улсын ИЕС-61850 цуврал стандартын шаардлага хангасан механик болон цахилгаан хоригтой байх Ашиглалтын заавар монгол хэл дээр байна.

Д/Д	Техникийн үзүүлэлт	Утга
Хүчдлийн трансформатор / КYN-28А-12 марктай дүйцэхүйц ячейк/		
1	Анхдагч талын хүчдэл (кВ)	10
2	Ажлын хамгийн их хүчдэл (кВ)	12
3	Давтамж (Гц)	50
4	Хоёрдогч талын хүчдэл (В)	100/√3 ; 100/3
5	Ажиллах орчны температур (°С)	-45.....+45
6	Ажиллах орчны байршил	Далайн түвшнээс дээш 1000 метрээс доошгүй өндөрт, хаалттай хуваарилах байгууламж дотор суурилуулна
7	Хүчдлийн трансформаторын холболтын бүлэг	Од, од, задгай гурвалжин
8	Цэнэг шавхагч	ОПНн-10/29
9	Баталгаат хугацаа	3 жил
10	Хэмжилт, туршилт	Тус ячейкт суурилагдсан тоноглолууд нь өндөр хүчдлээр туршигдаж хэмжигдсэн байна.

Нэмэлт шаардлага:

1. Ячейк нь стандартын шаардлага хангасан гадаа байрлуулах зориулалттай бүтүүмжлэл сайтай үйлдвэрийн монтаж угсралттай байна.
2. Ашиглагдах 10 кВ-ын хүчдлийн трансформатор нь Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилтанд хамрагдах боломжтой.

10 кВ-ын 10 кВ-ын ЯЧЕЙК БҮХИЙ СЕКЦ ХОЛБОГЧ ВАКУУМ ТАСЛУУРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

10 кВ-ын ячейк нь олон улсын ИЕС-61850 цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалттай, механик болон цахилгаан хоригтой, шинийн логик хамгаалалттай байх. Ашиглалтын заавар монгол хэл дээр байна.

Д/д	Техникийн үзүүлэлт	Утга
VS1-12 Вакуум таслууртай дүйцэхүйц		
1	Анхдагч талын ажлын хүчдэл (кВ)	10
2	Давтамж (Гц)	50
3	Аянгын хэт хүчдэл даах дээд утга (кВ)	75
4	Өндөр хүчдэлээр 1 мин турших дээд утга (кВ)	42
4	Ажиллах орчны температур (°С)	-40.....+40
6	Хэвийн гүйдэл (А)	1250
7	Хэвийн таслах гүйдэл (кА)	25
8	Богино залгааны гүйдэлд залгах хэвийн утга (кА)	63
9	Богино залгааны үргэлжлэх хугацаа (мс)	4
10	Таслах, залгах циклийн тоо (n)	50
11	Ажиллах нөхцөл	Далайн түвшнээс дээш 1000 метрээс доошгүй өндөрт, гадаа суурилуулна
12	Баталгаат хугацаа	3 жил
13	Хэмжилт, туршилт	Тус ячейкт суурилагдсан тоноглолууд нь өндөр хүчдлээр туршигдаж хэмжигдсэн байна.

Нэмэлт шаардлага:

1. Ячейк нь стандартын шаардлага хангасан гадаа байрлуулах зориулалттай бүтүүмжлэл сайтай үйлдвэрийн монтаж угсралттай байна.

0.4 кВ КАБЕЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн шаардлага	Утга
1	Ажлын хүчдэл (кВ)	1
2	Хэвийн хүчдэл (кВ)	0.4
3	Кабелийн хөндлөн огтлолын талбай (мм ²)	4
4	Кабелийн судал (тоо)	2
5	Давтамж (Гц)	50
6	Гадна орчны температур (°С)	-50.....+50
7	Далайн түвшин	1000 метрээс дээш өндөрт ажиллах боломжтой байх
8	Стандарт	ГОСТ-164442-80 стандартын шаардлагад дүйцэхүйц
8	Зөвшөөрөгдөх ачаалал (А)	43
9	Кабелийн дамжуулагчийн материал	Зэс
10	Кабелийн тусгаарлагчийн зузаан (мм)	1.0 багагүй
11	Богино залгааны гүйдлийн хязгаар (кА)	1.2

ХЯНАЛТЫН КАБЕЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Ажлын хэвийн хүчдэл (кВ)	0.4
2	Дамжуулагчийн материал	Зэс дамжуулагчтай /уян/
3	Тусгаарлагчийн материал	Резин эсвэл пластмасс тусгаарлагчтай байх
4	Хөндлөн огтлолын талбай (мм ²)	4 , 1,5
5	Дамжуулагчийн судал (тоо)	7 , 10
5	Орчны нөхцөл	Хаалттай болон зайдгай нөхцөлд суурилуулах
6	Ажиллах температур (°C)	-40..... - +40
7	Урт (м)	100
8	Кабелийн бүрээс	Хамгаалалтын бүрээстэй байх

ОПЕРАТИВ ХЭЛХЭЭНИЙ ТЭЖЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭР, БАТЕРЕЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүчдэл баригч нь дараах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн байна. Ашиглалтын заавар Монгол, Англи хэлээр байх

д/д	Оролт	
1	Хүчдэл (Vac)	120-276V
2	Давтамж (Hz)	50/60± 5% (50/60Hz ± 10%settings)
3	Гаралт	
4	Чадал (VA)	6KVA
5	Хүчдэл (Vac)	220/230/240±2%
6	Давтамж (Hz)	50/60±0.2%(battery mode)
7	Хэт ачаалал	105 секунд ~ 129% 60 секунд, 130 секунд ~ 150 секундэд 30 секунд
8		150% for 300ms
9	Батерай	
10	Хүчдэл (Vdc)	216
11	Батерайн төрөл	18ш, 38Ah, 12V
12	Холболт	RS232+USB+EPO (SNMP adapter, Dry contact are optional)

13	Дэлгэц	LCD эсвэл LED
14	Дохиолол	Зайн цэнэг буурсан, оролтын хүчдэл, хэт ачаалал, UPS-ийн алдаа
15	Хамгаалалт	Зай бага, хэт ачаалал, богино холбоо, UPS алдаа, хэт бага хүчдэлийн оролт
16	Ажиллах температур	/+5-40°C/
17	Ажиллах чийгшилт	0~95%,

ЦАХИЛГААН ГАГНУУРЫН ЭЛЕКТРОДНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Туршилтын температур (°C)	+20
2	Түр зуурын урагдалтын эсэргүүцэл (мОм)	450
3	Харьцангуй суналт (%)	18
4	Цохилтын наалдамхай чанар(Дж/см ²)	78
5	Гагнаасны гүйцэтгэл (г/мин)	23.5
6	Гагнах металлын харьцангуй гаралт (%)	90
7	1 кг гагнуурын давхаргад зарцуулах материалын зарцуулалт (кг)	1.7
8	Электродны хөндлөн огтлолын талбай (мм ²)	3

БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүлэгчийн санал болгосон бараа нийлүүлэх хугацаа	
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7

ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БАРАА МАТЕРИАЛЫН ГЭРЭЭ

Тендерт оролцогч одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				

2.				
3.				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дүгээр сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>1</i> жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. [Нийлүүлэхээр санал болгож буй материалыг эрх бүхий байгууллагаар туршилт тохируулга хийлгэж протоколын хамт ирүүлэх.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсаны дараа захиалагчийн гэрээ дүгнэсэн акт болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор төлбөрийг барагдуулна.
- .
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: *Гэрээний дүнгийн нэг хоногийн 0,5%*
- Алдангийн нийт дүн: *Гэрээний дүнгийн 10%*

